



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/264

Улаанбаатар хот

**Арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн A/194 дүгээр тушаалаар арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК нь гаргасан зөрчлөө арилгаж, гишүүнчлэлийн хөлс, арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлсийг бүрэн төлж барагдуулсан тул үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг сэргээхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК (Н.Оюунтунгалаг)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн A/194 дүгээр тушаалыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Тушаалын биелэлтийг хангуулж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд тус тус даалгасугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.ДӨЛГӨӨН

1525030544